

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль

## **Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	15
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	17
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	20
4. Менежментийн захидал.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

## ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН ЗАХИРАЛ Г.ЦОГГЭРЭЛ ТАНАА

2021.02.05 № 07/544  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний урлагийн их театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний урлагийн их театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Үндэсний урлагийн их театрын 2020 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 24 зорилт, 36 арга хэмжээний биелэлт 98.0 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,435,507,440.33	1,458,777,812.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	40,494.75
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	40,494.75
31110	Төгрөг	0.00	40,494.75
33	АВЛАГА	5,869,948.37	3,615,529.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	238,950.00	62,991.52
335	Бусад авлага	5,630,998.37	3,552,538.10
33520	Хувь хүмүүсээс авах авлага	5,630,998.37	3,552,538.10
35	БАРАА МАТЕРИАЛ	1,429,637,491.96	1,455,121,787.98
351	Түүхий эд материал	1,199,279,750.99	1,208,543,248.99
35110	Тусгай зориулалттай материал	1,199,279,750.99	1,208,543,248.99
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,143,561.44	3,910,375.00
354	Хангамжийн материал	226,214,179.53	242,668,163.99
35420	Аж ахуйн материал	221,214,179.53	238,198,163.99
35440	Түлш, шатах тослох материал	5,000,000.00	4,470,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	304,487,240.14	1,407,876,531.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	304,487,240.14	1,407,876,531.20
392	Биет хөрөнгө	304,487,240.14	444,647,151.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	213,347,827.25	483,347,827.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	-190,260,798.09	-236,703,507.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	327,317,343.79	311,508,117.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	-240,355,632.43	-252,149,945.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	230,755,850.94	223,501,168.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-163,310,433.56	-168,599,134.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	677,422,851.73	640,241,180.53
39215	Хуримтлагдсан элэгдэл	-550,429,769.49	-556,498,555.51
393	Биет бус хөрөнгө	0.00	963,229,380.00
39301	Програм хангамж	1,488,750.00	1,488,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,488,750.00	-1,488,750.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	963,229,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,739,994,680.47	2,866,654,343.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	108,272.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	108,272.00
413	Өглөг	0.00	108,272.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	108,272.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,739,994,680.47	2,866,546,071.55
51	Засгийн газрын хувь оролцоо	1,739,994,680.47	2,866,546,071.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	601,000,655.43	1,564,230,035.43
51101	Өмч: - төрийн	601,000,655.43	1,564,230,035.43
512	Хуримтлагдсан үр дүн	1,112,890,228.04	1,276,212,239.12
51210	Өмнөх үеийн үр дүн	875,577,737.74	1,112,890,228.04
51220	Тайлант үеийн үр дүн	237,312,490.30	163,322,011.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,103,797.00	26,103,797.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,739,994,680.47	2,866,654,343.55

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<b>3,147,616,400.00</b>	<b>3,408,630,142.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	604,312,700.00	270,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	604,312,700.00	270,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	604,312,700.00	270,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	604,312,700.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	270,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,543,303,700.00	3,138,630,142.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,543,303,700.00	3,100,781,792.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,543,303,700.00	3,100,781,792.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	37,848,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	37,848,350.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<b>2,910,303,909.70</b>	<b>3,245,308,130.92</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,910,303,909.70	3,245,308,130.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,700,018,477.43	3,135,677,378.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,116,087,032.25	2,503,705,755.82
210101	Үндсэн цалин	1,713,647,398.90	1,755,266,543.22
210102	Нэмэгдэл	299,873,633.35	633,602,812.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	102,566,000.00	114,836,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	271,863,172.46	312,428,061.22
210201	Тэтгэврийн даатгал	187,219,692.46	232,120,456.23
210202	Тэтгэмжийн даатгал	21,160,870.00	24,823,499.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,928,696.00	19,858,799.68
210204	Ажилгүйдлийн даатгал	4,232,174.00	4,964,799.41
210205	Эрүүл мэндийн даатгал	42,321,740.00	30,660,506.81
2104	Хангамж, бараа материалын зардал	8,963,355.00	61,038,189.41
210401	Бичиг хэрэг	2,580,895.00	1,682,027.60
210402	Тээвэр, шатахуун	2,745,000.00	4,030,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,100.00	632,300.00
210404	Ном, хэвлэл	121,400.00	403,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,440,960.00	5,083,039.25
210408	Бараа материал акалсны зардал	0.00	49,207,122.56
2105	Нормативт зардал	738,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	738,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,961,410.00	1,999,640.00
210604	Урсгал засвар	2,961,410.00	1,999,640.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	0.00
210701	Гадаад албан томилолт	564,800.00	0.00
210702	Дотоод албан томилолт	735,200.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,797,110.54	125,065,643.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	178,797,110.54	116,600,710.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	4,435,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	594,972.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	481,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	227,820.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	550,000.00
210807	Газрын төлбөр	0.00	2,175,341.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,308,397.18	131,440,088.94
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,275,664.92	131,440,088.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,285,432.27	109,630,751.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	204,555,172.00	105,490,220.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	79,030,220.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	204,555,172.00	26,460,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,730,260.27	4,140,531.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,730,260.27	4,140,531.96
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>238,612,490.30</b>	<b>163,322,011.08</b>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>238,612,490.30</b>	<b>163,322,011.08</b>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,149,436,293.56	3,138,630,142.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,819,893.06	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,819,893.06	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,819,893.06	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,819,893.06	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,147,616,400.50	3,138,630,142.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,543,303,700.00	3,100,781,792.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,543,303,700.00	3,100,781,792.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	604,312,700.00	37,848,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	604,312,700.00	37,848,350.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,064,454,213.56	3,136,989,647.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,064,454,213.56	3,136,989,647.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,854,168,781.29	3,027,358,895.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,121,174,316.91	2,482,356,472.70
210101	Үндсэн цалин	1,640,134,683.56	1,733,917,260.10
210102	Нэмэгдэл	299,873,633.35	633,602,812.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	102,566,000.00	114,836,400.00
210104	Урамшуулал	78,600,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,370,699.32	331,414,653.59
210201	Тэтгэврийн даатгал	180,299,816.00	232,120,456.23
210202	Тэтгэмжийн даатгал	21,211,743.00	24,823,499.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,969,394.00	19,858,799.68
210204	Ажилгүйдлийн даатгал	16,969,394.00	4,964,799.41
210205	Эрүүл мэндийн даатгал	29,920,352.32	49,647,099.18
2104	Хангамж, бараа материалын зардал	12,040,770.00	9,710,317.00
210401	Бичиг хэрэг	2,542,170.00	581,617.00
210402	Тээвэр, шатахуун	5,745,000.00	3,665,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	81,600.00	2,258,800.00
210404	Ном, хэвлэл	251,400.00	403,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,420,600.00	2,800,400.00
2105	Нормативт зардал	657,820.00	435,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	657,820.00	435,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,298,530.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,298,530.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	0.00
210701	Гадаад албан томилолт	564,800.00	0.00
210702	Дотоод албан томилолт	735,200.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	452,326,645.06	201,441,552.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	448,901,425.06	191,651,619.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	4,435,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	337,100.00	594,972.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	479,120.00	481,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,000.00	227,820.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	550,000.00
210807	Газрын төлбөр	0.00	3,175,341.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	325,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,285,432.27	109,630,751.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	204,555,172.00	105,490,220.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,555,172.00	79,030,220.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	181,000,000.00	26,460,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,730,260.27	4,140,531.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5730260.27	4,140,531.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	84,982,080.00	1,640,494.75
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	84,982,080.00	1,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	84,982,080.00	1,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	84,982,080.00	1,600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	84,982,080.00	1,600,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-84,982,080.00	-1,600,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	40,494.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	40,494.75

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/				
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	871,667,737.74	1,498,772,190.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,910,000.00	3,910,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	875,577,737.74	1,502,682,190.17
Тайлант үеийн үр дүн			237,312,490.30	237,312,490.30
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	1,112,890,228.04	1,739,994,680.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	1,112,890,228.04	1,739,994,680.47
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	963,229,380.00			963,229,380.00
Тайлант үеийн үр дүн			163,322,011.08	163,322,011.08
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,564,230,035.43	26,103,797.00	1,276,212,239.12	2,866,546,071.55

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	/төгрөгөөр/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,134,002,100.00	3,096,600,765.29	37,401,334.71	98.8
УРСГАЛ ЗАРДАЛ	3,134,002,100.00	3,096,600,765.29	37,401,334.71	98.8
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,020,975,800.00	3,017,160,545.29	3,815,254.71	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,482,356,500.00	2,482,356,472.70	27.3	100.0
Үндсэн цалин	1,757,229,300.00	1,733,917,260.10	23,312,039.90	98.7
Нэмэгдэл	608,760,400.00	633,602,812.60	-	104.1
Унаа хоолны хөнгөлөлт	116,366,800.00	114,836,400.00	1,530,400.00	98.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	335,118,000.00	331,414,653.59	3,703,346.41	98.9
Тэтгэврийн даатгал	235,823,800.00	232,120,456.23	3,703,343.77	98.4
Тэтгэмжийн даатгал	24,823,500.00	24,823,499.09	0.91	100.0
ҮОМШӨ-ний даатгал	19,858,800.00	19,858,799.68	0.32	100.0
Ажилгүйдлийн даатгал	4,964,800.00	4,964,799.41	0.59	100.0
Эрүүл мэндийн даатгал	49,647,100.00	49,647,099.18	0.82	100.0
Хангамж, бараа материалын зардал	5,201,200.00	5,201,200.00	0.00	100.0
Бичиг хэрэг	572,500.00	572,500.00	0.00	100.0
Тээвэр, шатахуун	665,800.00	665,800.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,258,800.00	2,258,800.00	0.00	100.0
Ном, хэвлэл	403,700.00	403,700.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,400.00	1,300,400.00	0.00	100.0
Нормативт зардал	435,900.00	435,900.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	435,900.00	435,900.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	197,864,200.00	197,752,319.00	111,881.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	192,363,500.00	192,251,619.00	111,881.00	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	337,100.00	337,100.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	481,600.00	481,600.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	550,000.00	0.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,026,300.00	79,440,220.00	33,586,080.00	70.3
Бусад урсгал шилжүүлэг	113,026,300.00	79,440,220.00	33,586,080.00	70.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	112,616,300.00	79,030,220.00	33,586,080.00	70.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	0.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,134,002,100.00	3,096,641,260.04	37,360,839.96	98.8
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,134,002,100.00	3,096,641,260.04	37,360,839.96	98.8
Улсын төсвөөс санхүүжих	3,134,002,100.00	3,096,641,260.04	37,360,839.96	98.8

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	40,494.75	-40,494.75	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
Төсвийн байгууллага	1	1		100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	189	189		100
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	175	175		
Үйлчлэх ажилтан	13	13		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		37,848,350.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		37,848,350.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		11,798,350.00
Хангамж, бараа материалын зардал		4,509,117.00
Бичиг хэрэг		9,117.00
Тээвэр, шатахуун		3,000,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,500,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		2,000,000.00
Урсгал засвар		2,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,289,233.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,000,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		435,200.00
Даатгалын үйлчилгээ		257,872.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо		95,820.00
Газрын төлбөр		3,175,341.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		325,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		26,050,000.00
Бусад урсгал шилжүүлэг		26,050,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		26,050,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		37,848,350.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		37,848,350.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		37,848,350.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний урлагийн их театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Г.Цоггэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож бүртгэх, өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөх, хөрөнгийн эдийн засгийн ангилал болон төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Ихэрмөрөн-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний урлагийн их театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ихэрмөрөн-Аудит” ХХК-д 2021 оны 1 сарын 22-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

“Үндэсний Дуу Бүжгийн Эрдмийн Чуулга” нь 2016 оны 11 дүгээр сарын 2-нд Монгол Улсын засгийн газрын 129 дүгээр тогтоолоор Үндэсний урлагийн их театр болж өөрчлөгдсөн.

Урлагийн их театрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол угсаатан ястны утга соёлын өвийн сор дээжийг сурталчлах, судлах, сургах хийгээд үйлчлүүлэгч, харилцагч түншүүдийнхээ эрэлт шаардлагад нийцсэн орчин цагийн болон дэлхийн сонгомол бүтээлийг урлах чадавх бүхий өндөр боловсролтой хамт олны бүрдлийг нэгтгэсэн мэргэжлийн урлагийн төв байхад оршино.”

Үндэсний урлагийн их театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Урлаг соёлын үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд явуулах
- Ажилтны ур чадварыг дээшлүүлэх
- Сургалт сурталчилгаа хийх

Монгол Улсын Их хурлын 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд тус тус өөрчлөлт оруулж, Соёлын яамыг байгуулж Засгийн газрын бүтцэд шинээр нэмж оруулснаар Үндэсний урлагийн их театр нь тус яамны хариуцсан чиг үүрэгт хамрагдсан байна.

Соёлын талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хуулиар олгосон нийтлэг болон тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 24 зорилт, 36 арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 98.0 хувьтай хэрэгжсэн байна.

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос Цар тахлын үеийн бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нөхцөл байдлын улмаас 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 6 дугаар сарын 21-ний өдрүүдэд соёл урлагийн байгууллагын үзвэр, үйлчилгээг хязгаарласан, 11 дүгээр сарын 11-ний өдрөөс хатуу хөл хорио тогтоосонтой холбоотой нийтэд үйлчилгээ үзүүлээгүй бөгөөд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар гарсан хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Үндэсний урлагийн их театр нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Нийгмийн даатгалын тухай хууль /нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт/
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2019 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 1 дүгээр хавсралтаар төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн олгож эхэлсэн байна.
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”

Тус байгууллага нь БСШУСС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 заалтад заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлан, мөрдөх талаар зөвлөмжийг хүргүүлсэн.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Соёлын яам нь 2020 онд сүүлийн хагас жилд шинээр зохион байгуулагдсантай холбоотойгоор тус яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Үндэсний урлагийн их театрт дотоод аудитыг хэрэгжүүлээгүй, 2020 оны шилэн дансны мэдээлэлд 2021 оны 1 дүгээр сард дотоод аудитыг хэрэгжүүлсэн, одоогоор дүнг албан ёсоор нэгтгэн ирүүлээгүй байна.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019



оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,910,303.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 29,103.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,245,308.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,453.0 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Үндэсний урлагийн их театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,126,659.6 мянган төгрөгөөр буюу 64.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн данс материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		40.5	40.5
Авлага	5,869.9	3,615.5	-2,254.4
Бараа материал	1,429,637.5	1,455,121.8	25,484.3
Үндсэн хөрөнгө	304,487.2	1,407,876.5	1,103,389.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,739,994.6</b>	<b>2,866,654.3</b>	<b>1,126,659.6</b>
Өр төлбөр		108.2	108.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,739,994.6	2,866,546.0	1,126,551.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,739,994.6</b>	<b>2,866,654.3</b>	<b>1,126,659.6</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 40.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь жижиг мөнгөн сангийн үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 3,615.5 мянган төгрөг болж 2,254.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд 3 хүнтэй холбогдох 15 жил болж байгаа 3,331.8 мянган төгрөгийн авлага байгаа бөгөөд оршин суугаа хаяг нь тодорхойгүй байгаагаас шүүхээр шийдүүлэх боломжгүй болсон нь авлагыг барагдуулахад эрсдэл үүссэн байна. Энэ нь нийт авлагын 98.2 хувийг эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,455,121.8 мянган төгрөг болж 25,484.3 мянган төгрөгөөр өсөхөд аж ахуйн материал дансны үлдэгдэл 16,983.9 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант жилийн эцэст 3,000.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч шатахууны үлдэгдэл 4,470.0 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,407,876.5 мянган төгрөг болж 1,103,389.2 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу 5.3 га газар авч 963,229.3 мянган төгрөгөөр үнэлж бүртгэлд тусгасан мөн ТӨБЗГ-ын А-1/1163 албан тоотын дагуу автобусыг орлогод авсан нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 108.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тэтгэвэрт гарсан 3 хүний гэрээгээр ажилласан хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүтэй тооцсоноос үүссэн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,866,546.0 мянган төгрөг болж 1,126,551.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 889,238.9 мянган төгрөгөөс нөлөөлсөн байна. Тайлант үеийн үр дүнд дээр дурьдсан үндсэн хөрөнгийн өсөлт нөлөөлжээ.

Үндэсний урлагийн их театр үндсэн үйл ажиллагааны орлогоор 37,848.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь өмнөх жилээс 566,464.3 мянган төгрөгөөр бага буюу 93.7 хувиар буурсан байна.

Улсын төсвийн санхүүжилт өмнөх жилээс 557,478.0 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй авсан хөрөнгө 270,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 261,013.7 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 557,204.7 мянган төгрөгөөр буюу 21.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал байна. Эдгээрээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон, Засгийн газрын 382 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн олгож эхэлсэнтэй холбоотой байна. Хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал нь өмнөх онтой харьцуулахад буурсан нь 2020 онд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төсвийн зарлагыг бууруулснаас шалтгаалжээ. Жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,140.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд 2020 онд ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу 5.3 га газрыг 963,229.3 мянган төгрөгөөр үнэлж, Засгийн газрын санг нэмэгдүүлсэн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,794,751.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,794,751.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 646,655.8 мянган төгрөгөөр бууруулж 3,148,095.5 мянган төгрөгөөр баталсан нь 2019 оны гүйцэтгэлээс 608,702.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ. Үүнд: цалингийн зардлыг 439,782.1 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 79,747.3 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 89,061.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна. Цалин шимтгэлийн зардлыг нэмэгдүүлсэн нь дээр дурьдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 1 дүгээр хавсралтаар төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн олгож эхэлсэнтэй холбоотой байна. Бусад бүлгийн зардлыг хорогдуулан баталсан байна. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг хамгийн их буюу 590,000.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлагатай байна.

Covid-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас хийсэн 2020 оны төсвийн тодотголоор Үндэсний урлагийн их театрын төсвийг 14,093.4 мянган төгрөгөөр бууруулан 3,134,002.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшууллыг олгохоор болж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусгахаар заасан байтал төсвийг төлөвлөж батлахдаа урамшуулалт цалин нэмэгдэл цалингийн дүнд оруулан баталсныг цаашид зөв ангиллаар батлах шаардлагатай байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлаг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж 3,134,002.1 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,100,781.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,096,641.2 мянган төгрөгийг зарцуулж 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Санхүүжилтийн үлдэгдэл 4,140.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2019 оноос эхлэн соёл, урлагийн байгууллагуудад орлогын төлөвлөгөө батлахгүй болсон. Ингэснээр тухайн байгууллага олсон орлогоо ажилчдын нийгмийн баталгааг хангах, цалин урамшуулал зэрэгт зарцуулах эрхтэй болсон. Үндэсний урлагийн их театр 2020 онд нэмэлт төсвийн дансанд тоглолтын орлогоор 22,848.3 мянган төгрөг, тоглолтын тайз түрээсийн орлогоор 15,000.0 мянган төгрөг нийт 37,848.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, өмнөх оноос 93.7 хувиар буюу 566,464.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ нь цар тахлын нөхцөл байдлын улмаас 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 6 дугаар сарын 21-ний өдрүүдэд соёл урлагийн байгууллагын үзвэр, үйлчилгээг хязгаарласан, 11 дүгээр сарын 11-ний өдрөөс хатуу хөл хорио тогтоож, нийтэд үйлчилгээ үзүүлээгүйтэй холбоотойгоор буурсан байна. Орлогыг Үндэсний урлагийн их театрын захирлын 2020 оны А/44, А/51 дүгээр тушаалуудаар ажиллагсдын нийгмийн асуудал шийдэхэд 26,050.0 мянган төгрөг, урсгал засварт 2,000.0 мянган төгрөг, шатахууны зардалд 3,000.0 мянган төгрөг, төсөвт тусгагдаагүй эх үүсвэр дутагдалтай зардлыг санхүүжүүлэхэд 6,789.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагаас шилэн дансанд мэдээлэх 173 мэдээллээс хугацаа болоогүй 4, хугацаа хоцроосон 2, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлэхдээ 2,366,407.0 мянган төгрөгийн 20 мэдээллийг, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 19,864.8 мянган төгрөгийн 2 гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэхтэй холбоотой 839,069.0 мянган төгрөгийн 33 шийдвэрийг тус тус шилэн дансанд мэдээлээгүй байсныг аудитын явцад шилэн дансанд нөхөж оруулснаар нийт 57 мэдээллийг хугацаа хоцроон мэдээллээ.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 29,957.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 акт, 7 албан шаардлага, 6 зөвлөмжийн хэрэгжилт 87.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	3,323.6	4	3,323.6		0	100
Албан шаардлага	7	24,300.0	5	24,300.0	2	0	71.4
Зөвлөмж	6	2,333.7	6	2,300.0		33.7	91.7
Нийт дүн	17	29,957.3	4	29,923.6	2	33.7	87.7

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,350,206.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,321,219.7 мянган төгрөгийн алдааг залруулж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн, шилэн дансанд оруулбал зохих мэдээллийг хугацаандаа оруулаагүй хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллаагүй, тайлант жилийн эцэст шатахуун худалдан авч их хэмжээгээр нөөцөлсөн 3 зөрчилд 4,470.0 мянган төгрөгийн албан шаардлага, өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож, бүртгэх, бараа материалыг зөв ангилж бүртгэх, Сангийн сайдын 2014 оны 55-р тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, мөрдөх 5 зөрчилд 24,516.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитын явцад 4,321,219.7 холбоотой мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. 2020 онд ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу 5.3 га газар авч 963,229.3 мянган төгрөгөөр үнэлж бүртгэхдээ үнэ төлбөргүй орлогоор бүртгэснийг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 5.5 заалтыг үндэслэн Засгийн газрын санг нэмэгдүүлж залруулсан.
2. Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг санхүүгийн үр дүнгийн тайланд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 79,030.1 мянган төгрөгөөр тайлагнасныг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд залруулсан.
3. Аудитын төлбөр 4,435.2 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн даатгал 594.9 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татвар 481.6 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөр 227.8 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээний төлбөр 550.0 мянган төгрөг нийт 6,289.5 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд бараа ажил үйлчилгээний бусад зардлаар тайлагнасныг холбогдох зардлын гүйцэтгэлд бичиж залруулсан.
4. Үндэсний урлагийн их театрын захирлын 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/18-р тушаалаар акталсан бараа материал 47,330.0 мянган төгрөгийг бараа материалын холбогдох зардлуудад бичсэнийг бараа материал акталсны зардал 210408 тоот дансанд залруулав.
5. Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоогүй боловч төсвийн ил тод байдалтай холбоотой, олон нийтэд зайлшгүй мэдээлэх шилэн дансны мэдээллийг аудитын явцад нөхөн оруулж 3,225,340.8 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

1. Тайлант хугацааны эцэст шатахууны худалдан авалт хийж, их хэмжээгээр нөөцөлж 4,470.0 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Төсвийн зардлын төлөвлөлтийг сайжруулж, төсвийг үр ашигтай удирдан гүйцэтгэлийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг жижиглэн шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4. заалтад "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангах, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлээгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

3. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6.4.4-т "таван сай төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр хаяг," 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь төсвийн ил тод байдал, "эрх ба үүрэг", "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд бүрэн байршуулж ажиллах албан шаардлага өгөх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 5 төрлийн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Үндэсний урлагийн их театрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитын албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нарийвчлан шалгаж, төсвийн төлөвлөлтийг гол анхаарах асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Үндэсний урлагийн их театр нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана."-ыг мөрдөөгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Эрсдэл: УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт хэрэгжихгүй байх, нягтлан бодох бүртгэлийг зохион байгуулахад ойлгомжгүй асуудал үүсэх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 заалтад заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөх.

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### 2. Балансын данстай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж буй 520 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 заалт "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалттай тус тус нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2. Эрсдэл: Хөрөнгийн өртөг бодит үнэ цэнээрээ илэрхийлэгдэхгүй байх, хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах, төрийн өмчийг үнэгүйдүүлэх, улмаар хөрөнгийг ашиглах, завших, хямд үнээр данснаас хасах эрсдэлтэй.
- 2.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС 21 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн хэрэгжилтийг хангаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож, бүртгэх.

##### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### 3. Балансын данстай холбоотой асуудал

- 3.1 Илрүүлэлт: Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн аж ахуйн материалд 13 төрлийн 2,717.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 449.5 мянган төгрөгийн эд

хогшил бүртгэлтэй байгаа нь “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 тоот тушаалаар батлагдсан балансын дансны /хөрөнгийн/ ангилалтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв”, “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл: Бараа материалыг үнэн зөв ангилж бүртгэхгүй байх нь хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэлтэй.

3.3 Зөвлөмж: “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалыг хэрэгжүүлж бараа материалыг зөв ангилж бүртгэх.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Цалингийн зардал 21,349.2 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлгээс шилжүүлж зарцуулсан нь Сангийн сайдын 2014 оны 55-р тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Эрсдэл: Төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх, төсвийг буруу зарцуулах.

4.3 Зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55-р тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 5 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

5.4 Илрүүлэлт: 2020 онд байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд 23 гэрээгээр 162,529.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авч гэрээний хэрэгжилтийг дүгнэж актаар баталгаажуулсан боловч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 48.1 дүгээр заалт, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 1.5 заалтад заасны дагуу тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаараа батлуулж, тайлагнаагүй нь “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.5 Эрсдэл: Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

5.6 Зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.1 заалт, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 1.5 заалтыг хэрэгжүүлж тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, мөрдөх.

5.7 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2021-02-21</b>	Аудитын нэр: <b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Үндэсний урлагийн их театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/71/СТА-ТШЗ</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		<b>Үндэсний урлагийн их театр</b>	<b>Мянган төгрөг</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн аж ахуйн материалд 13 төрлийн 2,717.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 449.5 мянган төгрөгийн эд хогшил бүртгэж, хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн.	3,167.4	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
2	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа 520 нэрийн 922,083.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий хөрөнгө бүртгэлтэй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
3	Цалингийн зардал 21,349.2 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлгээс шилжүүлж зарцуулсан.	21,349.2	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогтой уялдуулан боловсруулж мөрдөөгүй.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
5	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулаагүй	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
6	Тайлант оны эцэст 4,470.0 мянган төгрөгийн шатахууныг нөөцлөн,үлдэгдлээр тайлагнасан.	4,470.0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
7	Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	-	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
8	Байгууллагаас шилэн дансанд мэдээлэх 173 мэдээллээс 57 мэдээллийг хугацаа хоцроосон	-	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
<b>ДҮН</b>		<b>28,986.6</b>			





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 145/АОТ0063  
СЯТ-2021/41/СТА-ТЦЗ  
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үндэсний урлагийн их театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 173 мэдээлэл байршуулахаас 57 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр хаяг," 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний урлагийн их театрын захирал Г.Цоггэрэл, ерөнхий нягтлан бодогч Н.Батсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Б.МЯДАГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар\164.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 147/АД/70069  
САР-2021/71/СТА-ТЦЗ  
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үндэсний урлагийн их театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 4,470,000 /дөрвөн сая дөрвөн зуун далан мянган төгрөг/ төгрөгийн шатахууныг нөөцлөн үлдэгдлээр тайлагнасан байна. Мөн тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалт болон Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төлөвлөлтийг сайжруулж, төсвийг үр ашигтай удирдан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний урлагийн их театрын захирал Г.Цоггэрэл, ерөнхий нягтлан бодогч Н.Батсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Б.МЯДАГМАА



